

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ ЭЭЛЖИТ БУС ЧУУЛГАН

2024 ОНЫ 08 ДУГААР САРЫН 27-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2024 оны 08 дугаар сарын 27-ны өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>1</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>2-3</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>4-11</i>

1.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдтэй холбогдуулан гаргасан хууль зүйн дүгнэлт /Санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/	<i>4-11</i>
---	-------------

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит бус чуулганы
Хууль зүйн байнгын хорооны 08 дугаар сарын 27-ны өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 22 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 54.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 05 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Б.Энхбаяр;

Эмнэлгийн чөлөөтэй: Б.Бат-Эрдэнэ;

Тасалсан: Ж.Алдаржавхлан, Н.Алтанхуяг, Э.Бат-Амгалан, Х.Баттулга,
Д.Ганбат, Б.Пүрэвдорж.

Нэг.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдтэй холбогдуулан гаргасан хууль зүйн дүгнэлт /Санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн дарга М.Үнэнбат, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Галсанбат нар байлцав.

Улсын Их Хурлын Тамгын газраас гаргасан хууль зүйн дүгнэлтийг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа танилцуулав.

Хууль зүйн дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Г.Уянгахишиг нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар нар үг хэлэв.

Д.Цогтбаатар: Хууль зүйн дүгнэлтийн 3 дахь хэсгийг дэмжиж санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14
64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Дав.Цогтбаатар Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 32 минут үргэлжилж, 22 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 63.6 хувийн ирцтэйгээр 13 цаг 37 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Д.ЦОГТБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2024 оны 08 дугаар сарын 27-ны өдөр,
Мягмар гараг Төрийн ордон “Их эзэн
Чингис хаан” танхим 13 цаг 05 минут

**БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Д.Цогтбаатар: Ирц ингээд нэгэнт бүрдсэн байгаа учраас Байнгын хорооныхоо хуралдааныг эхлээд явж байна. Байнгын хорооны эрхэм гишүүддээ энэ өдрийн мэндийг юуны өмнө дэвшүүлье. Байнгын хорооны гишүүдийн ирц бүрдсэн тул 2024 оны 8 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. Байнгын хорооны ирц 54.5 хувьтай байна. Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Хуралдааны ирц Дамдины Цогтбаатар, Хүрэлбаатарын Баасанжаргал.

Хуралдаанаа түр завсарлуулаадахъя 5 минут. Техникээ хүлээе 5 минут. Техникийн нэг засвар зохицуулалт хийх гэж байх шиг байна. Манай гишүүд байж байгаарай.

Хууль зүйн байнгын хорооны хуралдаанаа эхлүүлсэн ингээд үргэлжлүүлээд явъя. Би юун дээр Хууль зүйн байнгын хорооны ирсэн гишүүдийг танилцуулж байгаа. Тэгээд гишүүд ирсэн байгаа. Гишүүдээ дахин танилцуулъя. Дамдины Цогтбаатар, Хүрэлбаатарын Баасанжаргал, Батжаргалын Заяабал, Лхагвын Мөнхбаатар, Мөнхтөрийн Нарантуяа, Салдангийн Одонтуяа, Ухнаагийн Отгонбаяр, Пүрэвжавын Сайнзориг,

Цэндийн Сандаг-Очир,
Хишигдэмбэрэлийн Тэмүүжин,
Гончигдоржийн Уянгахишиг, Даваагийн Цогтбаатар, Сүхбаатарын Эрдэнэболд гэсэн гишүүд ирснээр ирц 59.1 хувьтайгаар бүрдээд байна аа.

Ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлаа танилцуулъя. Хэлэлцэх асуудал нэг асуудал байгаа.

Яг одоо энэ хуралдаан дээр бол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдтэй холбогдуулан гаргасан хууль зүйн дүгнэлт байгаа.

Хэлэлцэх асуулт асуудалтай холбогдуулан саналтай гишүүд байна уу? Нэрсээ өгнө үү? Сайнзориг гишүүн байна. Сайнзориг гишүүнээр тасаллаа. Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Дарга аа би энийгээ зүгээр тодруулах гэсэн юм. Энэ нөгөө шинэ дэг явж байгаа учраас бас танин мэдэхүйн чанартай байж магадгүй ээ. Ер нь зүгээр энэ эрх зүйн дүгнэлт, хууль зүйн дүгнэлтийг яг Байнгын хороогоор хэлэлцүүлж байгаа ач холбогдол бий юу? Энэ асуудлууд нь аль хэдийн нэгдсэн чуулганаар хэлэлцэгдээд явчихсан байна. Энд ингээд бид хэд сонссоноор бас ямар үр дагавар байгаа вэ?

Би бол ер нь санал бас байгаа. Энэ бас нэг талдаа хуулиар хүлээж байгаа үүрэг боловч энэ асуудлыг бас эргэж хармаар байна аа. Эрх зүйн дүгнэлт гээд яг энэ төрийн жинхэнэ албан хаагчдыг бас энэ улс төрийн шийдвэр гаргах үйл ажиллагаанд хэт агуулга руу орсон ийм

дүгнэлтүүдийг гаргаад байна. Гаргасан дүгнэлтүүдийг мушгиж олон нийтийн сүлжээгээр явуулаад байна. Энэ хэд маань зөвлөөд байгаа байхгүй юу. Зөвлөсөн байна ингэж нийцээгүй байх талтай байна гээд байхад энэ юуг нь барьж авангуутаа Улсын Их Хурлын Тамгын газар нь энэ хууль дээр ингэж дүгнэлт гаргалаа гээд зарим улс төрчид нь ашиглаад байх юм аа.

Тэгэхээр алс алсдаа энэ бас хэцүү байж магадгүй. Бүх юмнууд дээр эрх зүйн дүгнэлт гээд. Сүүлдээ нөгөө гишүүд нь өөрсдийнхөө юу гэдэг юмаа судалж танилцаж шийдвэрээ гаргах биш эрх зүйн дүгнэлт гаргавал ч гэдэг юм уу ийм юм руу зүгээр аваад явчих тийм том эрсдэл байна.

Дээрээс нь одоо бас энэ эрх зүйн дүгнэлтийн энэ асуудал чинь өөрөө бас их сонин юм байна лээ. Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх асуудлаар дүгнэлт гарга гэхихсэн байгаа байхгүй юу. Тэгэхээр би энэ агуулга руу орсон ийм юмыг Улсын Их Хурлын ялангуяа төрийн жинхэнэ албан хаагчид энд боломжгүй ээ. Энэ чинь өөрөө нэг талдаа хуулийн тайлбар маягтай, хууль хэрэглээний юм болчихоод байгаа байхгүй юу. Тэгэхээр энийгээ бас бодолцож дараа дараагийн энэ дэгийг өөрчлөхдөө бас янзлахгүй бол энд өнөөдөр яах вэ зүгээр хууль явж байгаа ийм процессыг би ойлгож байна. Энэ алсдаа бүр том эрсдэл гарна. Сүүлдээ энэ хууль зүйн дүгнэлтийг зөв буруу сүүлдээ бүх зүйлүүд дээр энэ байгаа ажил хийж байгаа залуучуудыг чирч орж ирдэг. Эсвэл хууль зүйн дүгнэлт гаргах хүрээ хязгаарыг маш ойлгомжтой тодорхой болгохгүй бол болохгүй ээ л гэдэг дээр ийм юмыг зүгээр хэлж байгаа юм. Тэгээд би зүгээр л танин мэдэхүйн чанартайгаар Хууль зүйн байнгын хороогоор энэ хууль зүйн дүгнэлтийг хэлэлцэж байгаагийн ач холбогдол гэдэг юм уу үр дагавар юу вэ? 2 дугаарт бас

Дондогмаа дарга энэ тэр гээд бас шинээр удирдлагууд байгаа анхаарна биз.

Өчигдөр бол тэр Төсвийн тогтвортой байдлын хууль дээр жишээ нь хууль санаачлах эрхийг 3 сараар хязгаарлачихсан байгаа байхгүй юу. Нэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан хүн 3 сар хүрэхгүй гэж байгаа юм. Хэзээ ч Үндсэн хуулиар хууль санаачлах эрхийг хязгаарлаж болохгүй. Харин нэгдсэн консенсуст хүрэх асуудлаар хууль батлах квотын асуудал байдаг. Бид хэд энэ аливаа асуудлыг зөв хийхгүй сүүлдээ ингээд юу гэдэг юм ямар нэгэн нөхцөл байдал үүсчхээд байхад хууль санаачилж болдоггүй юм гээд байж болохгүй.

Хоёрдугаарт Үндсэн хуулийн ирц нийт мэргэжлийн Байнгын хороо гэдэг юм уу холбогдох Байнгын хороо 50 дээр нэмэх нь нэгээр ингээд хэлэлцээд эхэлж байхад тэр тодотголын хуулиар бүүр 100 хувь гишүүд ирж байж хэлэлцэнэ гэхихсэн байгаа шүү дээ. Ийм ийм зарчимгүй зүйлүүд бас байж болохгүй. Энэ чинь өөрөө эргээд төсвийн тогтвортой байдлын нэрийн цаана өөрөө ингээд хууль зүйн техник болоод маш олон өөр ойлголтуудын үр дагаврыг ингээд эвдээд байна шүү гэдэг зүйлийг л би хэлмээр байна аа. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Ач холбогдол гэхээсээ илүү үр дагаврыг нь л ярья. Үр дагаварт нь л ач холбогдол нь байгаа шүү дээ. Тэгэхлээр би үр дагавар нь юу вэ гэхээр нөгөө хуультай байхгүй юу, хуульдаа ингээд заачихсан. Тэгээд энийг нь одоо хэдүүлээ хэлэлцэхгүй бол цаашаа энэ асуудал чинь хэлэлцэх юм бол өөрөө зогсчих гээд байгаа байхгүй юу. Бид нар хэлэлцэж байж одоо цаашаа хэлэлцэх ёстой жишээлбэл яг энэ хэлэлцүүлгийн үеэр гарч ирнэ.

Хоёр асуудал дээр хэлэлцэх юм нь нээгдэж байгаа байхгүй юу. Тэгэхлээр энэ процессыг үндсэн хэлэлцүүлгийн энэ хэлэлцэх процессыг нээж өгөх үүднээс энийг нь явуулахгүй бол энэгүйгээр жишээлбэл хөндөгдөөгүй асуудал бол цаашаа явах боломжгүй. Нөгөө хуулиа өргөн барихдаа хөндөгдөөгүй ороод ирчихсэн байгаа асуудал нь манайхаар орж ирж бид нар энэн дээр нь дүгнэлт гаргаж байж тэр хөндөгдөөгүй асуудалд дараагийн хэлэлцүүлэг рүүгээ орох л үүд хаалга нээгдэх гээд байгаа тэ. Цөмийн энерги жишээлбэл.

Тийм учраас энэ дээр ийм үр дагавар нь ийм байгаа учраас хууль цаашаа нөгөө хэлэлцүүлэг явах үүд хаалгыг нь нээж өгч байгаа л ач холбогдолтой байгаад байгаа. Энэ дээр зүгээр нэг зүйлийг хэлэхэд энэ чинь нөгөө Дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулаад Дэгийн тухай хуулийн 42.2.2-т заачихсан байгаад байгаа зүйл бол яах вэ Хууль зүйн дүгнэлт бол тэртээ тэргүй хэлэлцэж байгаа Байнгын хороо нь тэр хүсэлтээ ажлын хэсэг нь гаргаад энэ хуулийг хариуцаад явж байгаа ажлын хэсэг нь тэгээд Байнгын хороо нь энэ дүгнэлт гаргах хүсэлт гаргачихсан байгаа бол хуулийнхаа дагуу ер нь Тамгын газар гаргахаас өөр үггүй болчхож байгаа юм. Тэгээд энийг ингээд гаргаад хэлэлцэж байхад яг хуучин бол зарчмын зөрүүтэй асуудлуудаар л энэ асуудал яригддаг байсан бол одоо бол яг энэ өөр хоорондоо яг зөрчилдсөн асуудлаар нь л өөрөөр хэлбэл өөрөө түрүүн тэр хүрээ хязгаарыг яриад байна шүү дээ. Яг тэр зөрчилтэй асуудлаар л дүгнэлт гаргахаар энэ Дэгийн хуульд бол туссан байгаа юм байна лээ. Яг тэр хүрээндээ авч орж ирж байгаа юм байна лээ.

Тэгвэл хариулт хангалттай болсон бол энэ асуудлынхаа хэлэлцүүлэгт орё. Улсын Их Хурлын

Тамгын газраас ирүүлсэн хууль зүйн дүгнэлтийг хэлэлцье.

Улсын Их Хурлын Тамгын газраас гаргасан хууль зүйн дүгнэлтийг гишүүдэд тараасан байгаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа Ажлын хэсэг, Үнэнбат дарга бас энд ирчихсэн сууж байна. Тийм ажлын хэсэгт би танилцуулчихъя ямар ч гэсэн. Ингээд Улсын Их Хурлын Тамгын газраас хийсэн хууль зүйн дүгнэлтийг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа танилцуулна аа. Дондогмаа даргыг микрофонд урьж байна.

Дондогмаа дарга сая би бас өөрөө нөгөө хууль танилцуулахдаа 42.2.2 байсан шүү дээ. Дэгийн тухай хуулийн. Яг энэн дээр зөрчилтэй 2 асуудлаа л танилцуулаад явчих уу? Нэг асуудал байгаа. Тийм зөрчилтэй нэг асуудлаа л танилцуулаад явчихъя аа. Бусад юун дээр нь угаасаа зөрчилгүй ажлын хэсэгтэйгээ ойлголцчихсон байгаа юман дээр бид нар энд танилцаад хэрэггүй байх. Баярлалаа.

Д.Цогтбаатар: 5 дугаар микрофон.

Ч.Дондогмаа: Байнгын хорооны гишүүдийн энэ өдрийн амгаланг эрье ээ. Төсвийн байнгын хорооноос Улсын Их Хурлын Тамгын газар хандаж ирүүлсэн албан бичгийн хүрээнд Улсын Их Хурлын Тамгын газрын Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсээс хууль зүйн дүгнэлтийг гаргасан байгаа.

Энэ дүгнэлтэд бол Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хууль, төсвийн

2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөл болон Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх талаар төслийн тодорхой зүйл, хэсэг, заалт хоорондоо зөрчилдсөн эсэх талаар дүгнэлт гаргуулж ирүүлэх тухай албан бичигт дурдсан байсан. Тэгээд энэний дагуу дүгнэлтийг гаргасан. Төсвийн эдгээр хуулиудыг хамт өргөн мэдүүлсэн 15 хууль, 2 Улсын Их Хурлын тогтоолын хүрээнд дүгнэлтийг гаргаад өнөөдөр Хууль зүйн байнгын хороонд зөрчилтэй гэж үлдсэн нэг хуулийн төслийн талаарх дүгнэлтийг уншиж танилцуулъя.

Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Хуулийн төсөлд Цөмийн энергийн тухай хуулийн холбогдох зүйлүүдэд “боловсролын” гэснийг “цөмийн энергийн” гэж өөрчлөхөөр тусгасан. Үүнтэй уялдуулан тус хуулийн 10.2-т Цөмийн энергийн комиссын дарга нь шинжлэх ухааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн байна гэж заасны шинжлэх ухааны гэснийг цөмийн энергийн гэж өөрчлөх шаардлагатай байсан. Энэ зохицуулалт хөндөгдөөгүй үлдсэн тул дүгнэлтээр гарсан саналын хүрээнд Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд хамруулбал зохих заалтыг орхигдуулсан гэж үзээд энэ зохицуулалтыг өөрчлөх нь зүйтэй гэсэн дүгнэлтийг гаргасан байгаа.

Д.Цогтбаатар: Дондогмаа даргад баярлалаа.

Ингээд Хууль зүйн дүгнэлтийн 3 дахь хэсэгтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрээ өгнө үү.

Сайнзориг гишүүнээр тасаллаа. Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Хууль зүйн байнгын хороо бас анхны жишигээ тогтоож байгаа учраас бас гишүүд маань анхнаасаа зөв мэдээлэлтэй байгаасай гэж бодож байна. Ер нь яах вэ зүгээр мэдээж дагаж орж ирээгүй хуулийг хөндөх эсвэл хөндөгдөөгүй заалтыг хөндөөд зарим өөрчлөлтүүд орсноос болоод хэтэрхий их хаширлаж бас иймэрхүү процесс руу орчихсон байна аа. Яах вэ нэг талдаа зөв байх, хяналттай байх нь зөв.

Хоёр талдаа бүх энэ асуудлуудын гал манай Хууль зүйн байнгын хороон дээр ирэх магадлалтай байна. Бид тэгэхээр нөгөө өмнөх мэргэжлийн Байнгын хорооны бас юмыг сайтар судлах зайлиггүй ийм шаардлага байна. Тэгэхээр гишүүд маань бид бас өндөр хариуцлагатай болж байгаа юм байна гэдгээ бас ухамсарлаарай гэж бодож байгаа юм.

Хоёрдугаарт ер нь хууль зүйн техникийн юмнуудыг бид хэд бас үнэхээр жишиг нь анхаарахгүй бол болохгүй байгаад байгаа юм. Зүгээр би жишиг нь цагдаагийн хуулийн тэр 26.2-ыг хүлээж авахад ганцаараа эсрэг байсан гол асуудал маань хүний эрхийг дордуулж байгаа гэдэгт бүгд санал нийлж байгаа боловч агуулгыг сэргээж болдоггүй байхгүй юу. Бид хүлээгээд авчихсан. Тэр юуны цаана түр саатуулах байранд хийж байгаа чинь угаасаа байх нэг хэлбэр байхгүй юу. Гэх зэргээр ингээд бодохоор энэ хууль зүйн процедурын цаана үүсэж байгаа энэ Үндсэн хуулийн гэдэг юм уу хууль хоорондын зөрчлийн процесс дээр л манай Улсын Их Хурлын Тамгын газар

илүү их зөвлөдөг байгаасай. Агуулга руу орох бас хэцүү. Тэгэхдээ энэ бол яах вэ агуулга гэхээсээ илүүтэй илэрхий зөрчлийг арилгаад явъя Засгийн газраас боловсруулахдаа дутуу байна гэдэг зүйл дээр байх шиг байна.

Тэгэхээр энэ зүйлүүдийг нь яах вэ зарчмын хувьд өнөөдөр дэмжиж байна. Цаашидаа нөгөө Цогтбаатар дарга ч бас хэлж байсан. Бид хэд дээр энэ шинэ дэгийн хуулиар маш олон жишгүүд тогтоож байгаа учраас энийг зөв тогтоох үүднээс л би асуулт асуугаад байгаа шүү. Энийг тэгээд нэгдсэн нэг ойлголттой болоод бас ингээд явъя. Тэгээд өнөөдрийн энэ илэрхий байна. Цааш цаашидаа маш төвөгтэй. Асуудлууд орж ирээд Хууль зүйн байнгын хороо сүүлдээ нэг ийм яадаг болдоо би жоохон болгоомжлол бол байна. Тэгэхдээ бид хэд асуудлыг шийдэхээс өөр арга байхгүй. Ер нь зүгээр яах вэ анхааръя гэдэг л байдлаар би одоо нэг их асуулт гэхээсээ илүүтэй үг хэлээд ингээд протоколд үлдээж байгаа юм аа. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Одоо энэ дээр чинь ингээд асуулт асуусангүй тийм ээ.

Энэ бол зүгээр саналаа хэлчихлээ гэж бодлоо. Энэ хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү? Уянгахишиг гишүүнээр тасаллаа. Уянгахишиг гишүүний микрофоныг өгье.

Г.Уянгахишиг: Ер нь яах вэ хууль зүйн дүгнэлт сая чуулган дээр гол асуудлууд буцчихсан учраас ерөнхийдөө бид нар ганцхан асуудалтай үлдлээ. Гэхдээ нэг тодруулмаар байгаа зүйл нь хэрвээ энэ асуудлууд буцаагүй байсан бол буюу хэлэлцэгдсэн бол бид нар хойноос нь хөөж орж ирж байгаа асуудал орж ирээд байгаа байхгүй юу. Өөрөөр хэлэх юм бол чуулган дээр яг энэ хөндөгдсөн асуудлууд яригдахаас өмнө

Хууль зүйн байнгын хороогоор хууль зүйн дүгнэлт хэлэлцэгдчихсэн байх ёстой байсан уу үгүй юү гэдэг асуудал гарч ирээд байгаа. Би нөгөө Золжаргалаас асууж байсан шүү дээ. Энэ хууль зүйн дүгнэлтээ бид нар өмнө нь ярилцах ёстой биш үү гараад ирчихсэн байна. Чуулган дээр яг энэ хуулийн зөрчлүүдтэй холбоотой зарчмын зөрүүтэй саналуудын санал хураалт явагдах гээд байна. Энэний өмнө бид нар хэлэлцэх ёстой биш үү гээд асууж байсан юм. Тэгэхээр энэ талаасаа энэ одоо ингээд Дэгийн тухай хууль дээр харахаар 39 яг одоо хууль зүйн дүгнэлт гаргуулах зохицуулалт нь байгаа шүү дээ.

Тэгэхээр энэ нь болохоороо хэлэлцэх эсэхийг хэлэлцэх үед гэдэг нэг үг үсэг байгаад байна. Бас анхан болон эцсийн хэлэлцүүлгийн өмнө гэдэг үг байгаад байна. Тэгэхээр яг энийгээ Хууль зүйн байнгын хороо өөрөө хууль зүйн дүгнэлтийг санал, дүгнэлт бэлдэх ёстой учраас Байнгын хорооны гишүүдийнхээ хувьд энэ дээр нэг бас тайлбар авмаар байна Тамгын газраас. Ер нь бол хууль зүйн дүгнэлтийг бид нар ямар тохиолдолд анхны хэлэлцүүлэг хийхээс өмнө авч хэлэлцсэн байх ёстой юм. Ямар тохиолдолд эцсийн хэлэлцүүлгийн өмнө гээд байгаа юм.

Дээрээс нь хууль зүйн дүгнэлт өөрөө 2, 3 янз байгаад байна л даа. Өөрөөр хэлэх юм бол шууд заавал хийгдэх ёстой. Заавал хууль зүйн дүгнэлт авсан байх ёстой асуудал гэж байна. Зарим нь бол гишүүдийн болон Байнгын хорооны хүсэлтээр авах хууль зүйн дүгнэлт гэж байгаад байна. Тэгэхээр энэ тал дээр бас тодорхой хэмжээнд тайлбар зөвлөмж авах боломж байх уу гэдэг хүсэлтийг Тамгын газарт тавимаар байна.

Д.Цогтбаатар: Уянгахишиг гишүүн ээ сая хараа одоо ингээд би нөгөө энэ Хууль зүйн байнгын хороон

дээр бид нар хуулиа бид өөрсдөө барьж жишиг тогтоох ёстой. Сая би асуултын сес чинь дуусчихлаа шүү дээ. Тэгээд одоо үг хэлэх юун дээр та асуулт асуучхаж байгаа байхгүй юу? Гэхдээ би хариулуулъя. Тамгын газраас дараа нь жич мэдээллээ авъя гэж байгаа юм уу? Ер нь бол сая таны хэлсэн юутай холбогдуулаад яг энүүхэндээ хэлэхэд Сайнзориг даргын ч гэсэн юутай холбогдуулаад нэг зүйлийг хэлмээр байгаа юм. Манай хуулиудад маш олон ийм юм байгаа. Манай хуулиудад энэ байгаа асуудлуудыг хэдүүлээ байгаа хуулийнхаа хүрээнд одоо ингээд өв тэгш биш байж болно. Төгс биш байж болно. Тэгэхдээ энэ хуулиуд чинь байж байгаа. Энийгээ бид нар дагаж мөрдөөд л явахаас өөр үггүй.

Одоо саяын юунд Тамгын газар бас тайлбар өгөх байх. Гэхдээ миний зүгээс бол энэ чинь яг хугацаагаа заагаад өгчихсөн байгаа байхгүй юу. Эцсийн хэлэлцүүлэг явуулахдаа санал хураахынхаа өмнө энэ ямар ямар нөхцөлүүд бүрдсэн байх ёстойг заагаад өгчихсөн дотор энэ санал, дүгнэлтийг хэлэлцээд дүгнэлтээ гаргачихсан байх ёстой. Тийм учраас одоо энэ нь орж ирж байгаа байхгүй юу. Түүнээс логикийн хувьд таны тэр хамгийн түрүүн энийг чинь ярих ёстой байсан юм биш үү гэдэг асуудал сая яг юун дээр Төсвийн тогтвортой байдлын хууль дээр л хэлэлцүүлэг дээр гараад ирж байгаа байхгүй юу. Энэ чинь хамгийн түрүүн яригдах ёстой байсан байгаа байхгүй юу. Бүх төсөв яригдаж дуусчхаад энэ асуудал нь орж ирээд энэ гацангуут яригдсан бүх төсөл энэ олон хоногийн 126 гишүүний хэлэлцсэн асуудал чинь өөрөө утгагүй болоод хэрэгжих боломжгүй болоод ирж байгаа байхгүй юу. Ингэнгүүт л хэлэлцүүлэх дэс дараа гэдэг чинь өөрөө маш том агуулгын бөгөөд эрх зүйн үр дагавартай асуудал байгаа байхгүй юу. Гэх мэтээр ийм юмнууд бол зөндөө

байгаа. Энийгээ хэдүүлээ цаг тухайдаа яриад явъя.

Тамгын газраас энэ дээр нэмж тайлбарлах юм байна уу? 5 дугаар микрофоныг өгье.

Ч.Дондогмаа: Уянгахыг гишүүний асуултад нэг тодруулга өгье. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 34.1-д 34 дүгээр зүйлд ер нь хууль зүйн дүгнэлт гаргах асуудлыг зохицуулсан байгаа. Энд бол 34.1-д Тамгын газар энэ хуулийн 33 дугаар зүйлд заасан болон олон улсын гэрээ соёрхон батлахаас бусад хуулийн анхдагч болон шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулахаас өмнө энэ хууль зүйн дүгнэлт гаргахаар зохицуулсан байгаа.

Саяын төсвийн хүрээний мэдэгдэл болон төсвийн тодотголыг дагаж орж ирсэн хуулиуд маань бүгд энэ дэгийн хуулийн 33 дугаар зүйл буюу нэн яаралтай горимоор өргөн баригдсан учраас энэ удаад энэ хууль зүйн дүгнэлт хийгдэж чадаагүй. Энэ 34 дүгээр зүйлийн 34.5-д заасан Байнгын хороо шаардлагатай гэж үзвэл төслийн тодорхой зүйл, хэсэг, заалт гишүүний гаргасан саналын томъёоллын хүрээнд анхны болон эцсийн хэлэлцүүлэг явуулахын өмнө хууль зүйн дүгнэлт гаргуулж болно гэсэн энэ зохицуулалтаар хууль зүйн дүгнэлт гарсан байгаа.

Хэлэлцэх эсэхээс өмнө бол нэн яаралтай горимоор биш байсан бол дүгнэлт гаргах боломжтой ийм дэгийн зохицуулалттай байсан.

Д.Цогтбаатар: Сайнзориг гишүүний микрофоныг өгчихье. Би бол их зөөлөн хандаад байгаа шүү. Гэгэхдээ гишүүдийнхээ үгийг нэг сонсоно.

П.Сайнзориг: Баярлалаа. Би тэгэхдээ манай гишүүд болон Тамгын газрынхан маань зөвөөр хүлээж аварай. Би хэн нэгнийг буруутгаж байгаа юм биш. Тэгэхдээ энэ дүгнэлтийн нэг хэсгийг би хэлэхгүй бол болохгүй байгаа юм аа. Төр хувийн хэвшлийн түншлэлийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл дээр гаргасан дүгнэлтээ бодолцоорой.

Өөрөөр хэлэх юм бол энэ Концессын хуулийн үйлчлэл нь өөрөө эргээд төр хувийн хэвшлийн түншлэл болж нэрээ л өөрчилсөн байхгүй юу. Үргэлжлээд явж байгаа юм.

Хоёрдугаарт Концессын хууль дээр хэрэглэгдэж байсан зарим харилцааны үр дагаврыг дагаж мөрдөх журмын хуулиар шилжилтийг хийсэн. Хийхдээ дутуу орхисон байна. Өнөөдөр явж байсан тэр харилцааг яах вэ гэдэг дээр зүгээр шийдэл орж ирсэн. Би тэгэхдээ энийг баталъя гэж байгаа юм биш үү. Ийм кейсүүд зөндөө гарч ирнэ ээ. Тэгэхээр манай энэ сая Улсын Их Хурлын тамгын газрын гаргасан дүгнэлтээр цаашидаа дагаж мөрдөх журмын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хязгаарлаад хаячихлаа болохгүй гээд. Энэ өөрсдөө Тамгын газрын гаргаж байгаа энэ дүгнэлт буруу байхгүй юу. Зөвхөн зүгээр энэ агуулгын хувьд юу байсан бэ гэхээрээ энэ асуудал нь одоо юу гэдэг юм зохимжгүй гэдэг юм уу ийм байдлаар улс төрийн шийдвэр гаргаад явах байж ээ гээд улс төрийн шийдвэрээ гаргах ёстой байхад агуулга руу ороод хууль зүйн зөрчил байна гээд сүүлдээ ингээд дагаж мөрдөх журмын хуулиуд баталдаг. Энэ дээр жижиг алдаа гараад тэрийгээ засаж болохгүй өмнөх хуулийн юмнууд байна гээд. Тэгэхээр бид хэд энэ хууль зүйн техникүүдийг ингэж баллаж болохгүй. Энийг манай залуучууд ойлгооч ээ. МУИС ч энэ асуудлыг заадаггүй. Бид хэд

ингээд өөрсдөө энд бүгдийг нь будаа болгоод хийж байгаа. Одоо жишээ нь сүүлийн үед гишүүд маань энэ эрх олгосон заалт буюу повер офф делигэйшин гэдэг хууль зүйн техникээ бүүр үзэн ядацгааж байна журам гаргахыг хязгаарлаж байна. Журмаа хэнд өгөхөө л бодох хэрэгтэй. Дээрээс нь Улсын Их Хуралд өргөн барихад дагалдан гаргах журмуудыг бүгдийг нь өргөн барьчихсан байх ёстой байхгүй юу хамтад нь. Энэ шаардлагаа бид нар тавьж чадахгүй байж байж байгаа хууль зүйн техникүүдийг буруушаадаг ийм зүйл рүү ингээд ороод. Энэ ерөөсөө л хууль ёсонд нь нийцэхгүй байна ч гэдэг юм уу.

Ингээд байхаар бид хэд чинь ерөөсөө сүүлдээ нэг зарчим горимоо олохгүй байна аа. Энэ дүгнэлтээ бол зүгээр яах вэ би залуучуудыг ажил хийж байхад нь мохоох гэж байгаа юм биш, буруутгаж байгаа юм биш. Хаа хаанаа шинэ жишиг тогтоох гэж байна. Тэгэхдээ асар үр дагавартай юм болсон юм шүү. Энийг ингээд бариад дараа нь явах юм бол ийм зүйл байдаггүй юм байна гээд дагаж мөрдөх журмын хуулиуд баталчихсан. Тэрний нэг жижиг тодотголыг хийгээд алдаа гарчихжээ. Энийг нь хийчихье гэхэд болохооргүй болчихож байгаа байхгүй юу. Зүгээр энэ Концессын хуулийг дагаж мөрдөх журмыг улс төрчид нь үлдээх ёстой байсан. Кнопоороо шийдэх буюу энэ хуулийн харилцааг бол үр дагаврыг нь яаж зохицуулах эсэхээ Улсын Их Хурал өөрөө шийдэхээр байна гэж л дүгнэх ёстой байтал огтоосоо хууль зөрчиж ийм юм байдаггүй юм гэдэг нэг хууль зүйн техникийг үндсэндээ ингээд бид хэд хэрэглээгүй болгож цаашидаа яах вэ гэдэг асуудлыг их сонин болгоод тавилаа. Тэгээд бодолцоно биз дээ. Би энийг зүгээр протоколд тэмдэглэж байгаа юм. Би яг энэ асуудал дээр одоогоор бас цөөнх яваад байгаа. Тэгээд энийг яах вэ зүгээр хожим нь бас энэ

асуудлууд яригдах байх аа. Тэгээд бас энэ зүйлүүдийн үр дагавар бас хожим нь бас жоохон хэцүү гарч магадгүй учраас л протоколд үлдээж байгаа гэдэг зүйлийг хэлье. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Гишүүд үг хэлж дууслаа. Би өөрийнхөө зүгээс нэг хэдэн зүйл хэлчихье ээ. Энд нэг зүйлийг яримаар байна энэ нээрээ одоо ингээд хуулийн дүгнэлт гаргаж байна гэдэг чинь Улсын Их Хуралтай Хууль зүйн байнгын хороо гэдэг бол хуулийн асуудлаар нарийвчлан мэргэшсэн хороо гэж үзэгдэж эхлэх нь байна шүү дээ. Улсын Их Хурлын хууль тогтоох дээд байгууллагад ингэж үзэгдэнэ гэдэг бол энэ маш хариуцлагатай ажил. Өөрөөр хэлбэл хуулийн дараагийн одоо ингээд амьдралд гараад нөгөө хууль чинь хэрэглэгдээд эхлэхэд тайлбарт өнөөдөр энд хууль зүйн яригдаж байгаа дүгнэлт тайлбарууд эд нар ёстой харин бодитой хэрэглэгдэж эхлэх асуудал болж байгаа байхгүй юу. Тэгэхээр үнэхээр энэн дээр нэн хариуцлагатай хандах ёстой болж байгаа. Нэг онцлог нь бол Хууль зүйн байнгын хороонд бүгдээрээ хуульчид байх албагүй. Энэ чинь өөрөө улс төрийн байгууллага болохлоор. Ингэнгүүт аягүй мэргэжлийн асуудал дээр бид нар санал хурааж шийдээд байгаа байхгүй юу. Энэ бол өөрөө асуудал дагуулах эрсдэл байгаа юу гэвэл байгаа. Гэхдээ байгаа механизм чинь л энэ. Зүгээр нэг юм байгаа юм. Эцсийн дүндээ хууль дараа нь гараад хэрэгжээд эхлэхэд шүүх дээр яг мэргэжлийн байгууллагууд дээр л энэ чинь хэрэгжээд явах болохоор тэрэн дээр дэнс нь одоо гарч ирнэ. Дүн нь тавигдана. Амьдрал дээр тэгээд буцаад засагдах энэ боломжууд нь нээлттэй. Зүгээр яг цэвэр эрх зүйн үүднээс аваад үзэхэд энэ чинь яг ийм асуудал гарчхаад байгаа байхгүй юу.

Эмч хүн энэ хүн ханиадтай байна гээд оруулж ирэхэд энийг хүлээж авах уу үгүй юу гэдэг тал дээр уг нь дүгнэлт

гаргана уу гэхээс энд суучхаад улс төрийн энэ хүн ханиадтай байна аа ханиадгүй байна гэдэг дүгнэлтийг бид нар энэ санал хурааж гаргах гээд байгаа байхгүй юу. Энэ одоо яг бодит байж байгаа байдал аягүй олон юман дээр энэ аудитын дүгнэлтийг хэлэлцэж байхад ч гэсэн аудитын дүгнэлтийг бид нар тэгж хүлээж авах уу, үгүй юу гэдэг талаасаа биш. Энэ зөв үү буруу юу гэж санал хураагаад байгаа байхгүй юу. Тэгэнгүүт аудитын хүмүүс биш шүү дээ. Энийг чинь зөв буруу юу гэж тийм юу гаргах мэргэжлийн тийм байгууллага Их Хурал хэчнээн том байгаа ч бас биш байхгүй юу. Гэх мэт ийм зөрчлүүд бол байгаа юм. Тэгээд манай Улсын Их Хурлын гишүүд энэ юмнуудыг өөрсдөө ажиглаад хуулиа засах эрх та нарт л байгаа. Ийм дутагдлуудыг харж байгаа бол Сайнзориг гишүүнээ ийм дутагдлуудыг харж байгаа бол засах санаачилга гаргах хууль боловсруулах эрх чинь та нарт л байгаа.

Тийм учраас энэ дээр та нар дутагдлууд харж байгаа бол энийгээ нээрээ ярьж байх хэрэгтэй. Хуулиа санаачлаад ороод ирэх боломжтой шүү гэдгийг хэлэх гэсэн юм аа. Ингээд гишүүд үг хэлж дууслаа. Саяын юу зөрчилтэй асуудлаар тэгэхлээр танилцууллаа.

Нөгөө бусад асуудал дээр нь ямар нэгэн зөрчил байхгүй учраас Дэгийн тухай хуулийнхаа дагуу ч энд бид нар хэлэлцсэнгүй шүү. Ажлын хэсэг эд нартайгаа ойлголцчихсон учраас. Одоо бол яг энэ зөрчилтэй асуудлаа Дэгийн хуулийнхаа дагуу л бид нар хэлэлцээд одоо санал хураах гэж байна. Тэгэхээр санал хураалтаа явуулъя.

Хууль зүйн дүгнэлтийн 3 дахь хэсгийг дэмжиж санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлэх нь

зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

64 хувиар дэмжигдлээ. Яг түрүүний Сайнзориг гишүүний ярьж байсан асуудал одоо энэ дээр гарч байгаа байхгүй юу. Энэ дэмжихээс өөр ямар ч сонголт байхгүй зөв юу байхгүй юу? Та нар одоо бод доо. Бид дэмжээгүй бол яах вэ? Энэ чинь балай юм болох гэж байгаа байхгүй юу. Тэгэхдээ одоо өнөөдөр хууль маань л ийм байна. Тэгэхээр цаашидаа аягүй нарийн асуудлууд дээр, ялангуяа энэ Сайнзориг гишүүний хэлж байгаа агуулгын асуудлууд дээр бид нар орж ирээд байх юм бол жижигхэн шүүх болж хувирч байгаа байхгүй юу даа. Байдал л ийм байж байна. Тэгээд энэн дээр тэр юунуудаа харж байгаа бол бид нар яаж засаж болох вэ? Би бол нээлттэй байгаа

шүү. Энэ саналуудаа орж ирээд ярилцацгаагаарай. Санал сая 64 хувиар дэмжигдсэн.

Хууль зүйн юу дүгнэлтийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг Төсвийн байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатар танилцуулна. Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье ээ. Гишүүддээ талархаж байна. Баярлалаа.

13.37 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ П.МЯД
АГМАА